



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 05 өдөр Дугаар 32

Хэрлэн сум

XXXII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын цомхотгосон хурал 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 11:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94.4 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. "Петрочайна дачин тамсаг" компанийн газрын тос тээврийн туслан гүйцэтгэгч компанид хийсэн шалгалтын талаар танилцуулах:

*Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа*

2. "COVID-19" өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн иргэний шинжилгээний хариу дүнгийн тухай танилцуулах:

*Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа,*

3. "МОНСЕК" үнэт цаасны компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдийн бөөгнөрөл үүсч байгаа талаар хэлэлцэх:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах,*

4. "Амны хаалтаа зүүцгээе" аяны хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан талаар хэлэлцэх:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах,*

5. Номын сангийн уншлагын танхимыг нээх эсэх талаар хэлэлцэх:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах,*



## ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

1.1.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч “Жилин хуа ян” ХХК-нд хяналт, шалгалт хийхэд гарсан зөрчлүүдийг арилгуулах хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг бүрэн хангатаг тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоохыг,

1.2.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний туслан гүйцэтгэгч “Мост-Ази”, “Дорнын хөгжил транспорт” ХХК-ууд өвчнөөс урьдчилан сэргийлэх халдвар хамгааллыг сахиулах талаар Мэргэжлийн хяналтын газраас 3 хоногийн хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан хяналт тавихыг,

1.3.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д ажилчдын ээлж солих зөвшөөрөл авах, ээлж солих үеийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, ажилчдыг тээвэрлэхдээ 8-аас ихгүй зорчигчтой байх тухай чиглэлээр албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх, Хэрлэн сум руу ороход асуумж авах, ариутгал халдваргүйтгэл хийж оруулах, хяналт тавьж ажиллахыг,

1.4.Шинэ төрлийн Коронавируст халдвар /COVID-19/-ийн эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж байгаа тул ээлж солих болон бусад туслан гүйцэтгэх компанийн ариутгал халдваргүйтгэл хийх зардлыг гаргуулах тухай албан бичгийг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д хүргүүлэхийг,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой

комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.1.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч компанийн жолооч иргэн Б-гын шинжилгээний хариу ХӨСҮТ-өөс ирсний дараа шинжилгээний хариуг үндэслэн хавьтлын иргэдийг хяналтаас гаргах эсэхийг шийдвэрлэхийг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой

комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

3.1.“МОНСЕК” үнэт цаасны компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдийн бөөгнөрөл үүсч байгаад шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллахыг,

Дөрөв. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой

комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

4.1.Худалдаа үйлчилгээний байгууллагуудад коронавируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дуут мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд нэгдсэн журмаар хүргэхийг,

4.2.Худалдаа үйлчилгээний байгууллагуудад гар ариутгагч байрлуулах, хаалганы бариулыг тогтмол халдваргүйжүүлэх уусмалаар арчих тухай мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх,



АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,  
Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа нарт:

4.3. Үйлчилгээний байгууллагуудад ажилчид, албан хаагч нар тогтмол амны хаалт зүүх, бээлий өмсөж иргэдэд үйлчлэх тухай чиглэл өгөхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт

4.4. Өсвөр насны хүүхдүүд, тэр дундаа эрэгтэй хүүхдүүд гудамж талбайд байрлуулсан сагсан бөмбөгийн талбайд олноор цугларч байгаа тул хөл хорионы энэ үед сагсан бөмбөгийн цагирагийг авах, талбайг цоожлох, тоглоомын талбайд ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг Сууц өмчлөгчийн хороодтой хамтарч зохион байгуулахыг,

Тав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа нарт:

5.1. Улсын Онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 21 дүгээр хуралдааны 1.2 дахь заалтыг үндэслэн нэг танхимд 10 хүнээс ихгүй үйлчлэх, Эрүүл мэндийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан зөвлөмжийн баримтлаж номын сангийн үйл ажиллагааг эхлүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА